

гийн хийдэд хадгалж байсан бөгөөд зун цагийн их Хайлин гэдэг тусгай дэглэмт 45 хоногийн хурлаар жилд нэг удаа үсэгчлэн уншиж Дашчойнпил дацанд хурдаг байсан учир тэр үеийн нэг зиндааны багачууд бид даах хирээр авчирч уншуулаад Гандантэгчлэнд буцааж байрлуулдаг байв. Ингээд энэ Ганжуурыг балчир багадаа эцэг, эхээ дагаад Хүрээ, Гандан, Голын цагаан сүмийг дан давхар тойрч, өсөх насандаа Гандантэгчлэн хийд Дашчойнпил дацан хоёрын хооронд үүрч зөөж байгаад бүр сүүлд 1980 онд УНН-ын санд ахлах номын санч, төвд хэлний орчуулагч, эрдэм шинжилгээний ажилтан гэдэг сайхан алдрыг хүлээж байх үедээ «нүхэт» Ганжуурын 110 ботийг ядаж олон жилийн тоос шороог арилгаж бас чадвал нэг удаа уншиж хэрэгтэй зүйлийг тэмдэглэж авах санаатай судрын аймгаас эхнээс хэдэн боть уншаад, бас цааш нь боть бүрт тодорхой нэгэн ижил хаяг (дондар) хийж эхэлсэн боловч орон тооны илүүдэл гэдгээр ажлаас гарч одсон билээ. Эртний соёлын түүх дурсгалаар баян, Энэтхэг төвдийн их бага арван ухааны эрдмийн цоморлог Дорнодахины соёлын харьцааны нэгэн хэрэглүүр болох «Жал-зээ-тэм-бан» буюу «нүхэт» хэмээх бичмэл Ганжуурын эрт эдүгээгийн түүх намтрыг өгүүлэхэд ийм ажээ.

Одоо энэ судар УННС-ийн алтан фондод нандигнан хадгалагдаж орчин цагийн залуу эрдэмтдийн судалгааны ном болоход бэлэн байна.

<sup>1</sup>Ганжуурын лүнгийн жүдрэм сэнвэрээ нацаг. (Ганжуур уншсан лам нарын үндэс дарааллын тэмдэглэл элдэв зүйл)

<sup>2</sup>Зая бадидаа Лувсанпэрэнлэйн (са-ег) номын 3-р боть

<sup>3</sup>Нанзаддорж агримбийн зохиол Данзэ-нацаг (шашны түүхийн элдэв тэмдэглэл)

**«ДЭНБЭРЭЛДОДВА  
RTEN-BREL-BSTOD-PA»  
ХЭМЭЭХ ЗОХИОЛЫН  
МОНГОЛ ОРЧУУЛГА  
ТАЙЛБАРЫН АСУУДАЛД**

**Р. Бямбаа**

XIV зууны үеийн төвдийн гүн ухаантан Зонхава (1357-1419)-гийн магтаалын<sup>1</sup> зохиолоос Монгол, Төвдөд үлэмж алдаршиж эрдэмтдийн анхаарлыг татсан зохиол бол «Дэнбэрэлдодва» буюу «Шүтэн барилдсан магтаал»<sup>2</sup> хэмээх зохиол юм.

Энэ магтаал нь нийт 58 шүлгээс бүрдсэн жижиг хэмжээний зохиол бөгөөд уг зохиолыг юунд зориулан зохиосон болон хаана бичсэн зэрэг баримт төгсгөлийн үгэнд тодорхой байна.

Харин зохиогч уг магтаалыг хэдүйд зохиосноо тодорхой бичээгүй тул хэдүйд зохиосон болохыг Зонхавагийн намтар зэрэг зарим төвд сурвалжийн мэдээгээр тодруулан үзье.

XIII зууны үеийн Монголын эрдэмтэн Цахар гэвш Лувсанцүлтэм (1740— 1810) 1791 онд зохиосон Зонхавагийн намтарын 5-р бүлэгт « (Зонхова) 42 насны шорой барс жилийн хавар намар хоёр Дагвалха-

дин гэдэг газар хоосон чанарыг бясалгаж байх үед бурханд буцалтгүй сүжиг төрж, гүн шүтэн барилдалгааны үүднээс сайшаалыг өгүүлсэн магтаал сайн номлолын зүрхэн хэмээхийг зохиосон»<sup>3</sup> гэсэн ба мөн намтрын хураангуйд ч «42 настайдаа бурханд сүжиглэснээс магтаал сайн номлолын зүрхэнг зохиосон»<sup>4</sup> гэж бичсэн байна. Үүнээс үзвэл Зонхава «Дэнбэрэлдодва»-г билгийн тооллын VII жарны шорой бар жил буюу аргын тооллын 1398 онд зохиосон болно.

Энэ зохиолын утга санаанаас үзэхэд Зонхава уг зохиолдоо, аливаа юмс үзэгдлийн шүтэн барилдаж ямар нэг зүйлд харгацан бий болж, хувирч өөрчлөгдөж байдаг нь түүний мөн чанараараа бүтээгүй буюу хоосон чанартай болох онолыг үндэслэсэн Буддаг «шүтэн барилдлага» буюу «хоосон чанар»-ын үзлийн үүдээс магтаж, мөн үзлийн талаар өөрийнхөө баримталдаг санааг нэгтгэсэн байна.

### 1. Монгол орчуулгын тухай

«Дэнбэрэлдодва» ингэж зохиогдсон цагаасаа хойш монголын эрдэмтдийн анхаарлыг их татаж байсан бөгөөд түүний тод жишээ бол уг зохиолыг монголчууд эх хэлдээ удаа дараа орчуулж, түүнд төвд хэлээр олон тайлбар бичсэнээр гэрчлэгдэнэ. Иймд уг зохиолын монгол орчуулгын тухай өгүүлбэл:

Ер нь Зонхавагийн бүтээлийг төвд хэлнээс анх монголчууд орчуулсан бөгөөд тэрхүү ажил нь Данжурыг төвд хэлнээс монгол хэлнээ орчуулах үед эхэлсэн бололтой байна. Монгол шунхан Данжурын гарчгийн оршилд энэ тухай өгүүлэхдээ «...зарлигаар сайшааж цол тамга хайрлагдсан Билэгтнотун хан бээр бурхны шашин ер хийгээд дэлгэрүүлэхийн маш арилсан сайн санаагаар хэв сийлэхийн харамжийг өөрөөн гаргаж, хамгийг айлдагч богд Зонхавагийн бум зарлигийг хэв дор богд эзэн бээр баясан таалж, зарлигаар зөвшөөн соёрхогдсон ёсоор тэдгээр шастируудыг шинэ орчуулж хэв дор сийлсэн Данжур эрдэнийн тоо бичиг зохиохуй дор хуучин нугууд нь хамгийг айлдагч тавдугаар Далай лам (Лувсанжамц, 1617—1682) зохиосон тоо бичиг мэт бөгөөтөл шинэ нэмсэн богд хамгийг айлдагч Зонхавагийн гэгээний бум зарлиг зэрэг ануу»<sup>5</sup> гэсэн байна. Энд Халхын Билэгт гүүш номун хан Зонхавагийн бүрэн сүнбүмийг орчуулж, Данжурт оруулж хэвлэхийг санаачилсан бөгөөд түүнийг бүтээх бүх зардлыг өөрөөсөө гаргана гэдгийг амласан байна. Тэрчлэн То ван гэж алдаршсан Тогтохтөрийн (1797—1887), «Цагаан толгойн үсгийг туурвисан оюун билгийн соёрхол» хэмээх цагаан толгойн оршилд байгаа нь эдгээр зүйлийг дахин баталж он цагий нь тодруулж байна. Түүнийг иш татвал: Бас Найралт Төв хан (1723—1735) бээр хоёрдугаар онд (1724) хуучдын Билэгт номун хан ламыг тамга барьж бүхий үед зарлиг буулгаж Данжур орчуулахад Номун хаан бээр ману багш болгосон Жэринбочи-гийн сүмбүм 20 ботийг хамтаар орчуулсугай хэмээн айлдсан дор ёсоор болгож, басхүү Жанжа Агванчойндон (1642—1714) гийн долоон сүн бумыг хамтаар орчуул хэмээн зарлиг буулгаснаар цөм монгол үсгээр энэ мэт их хөлгөн судрууд орчуулсан тухай номын ертөнцийг үзэх мэдэхүй хялбар болгосон»<sup>6</sup> гэжээ. Эдгээр мэдээнд Зонхавагийн сүнбүм орчуулагдсан гэж өгүүлж байгаа боловч гүйцэд орчуулга эдүгээ хүртэл хараахан олдоогүй ганц нэгэн номын орчуулга мэдэгдэж байгаа юм.

Харин энэ мэдээнүүд бидэнд «Шүтэн барилдсан магтаал»-ыг энэ үед орчуулсан, эсвэл үүнээс өмнө орчуулсан байж болох таамаглалыг төрүүлж байна. Гэтэл бидний судалгааны хүрээнд тэр үеийн орчуулгаас арай өөр гурван монгол орчуулга мэдэгдэж хоёр нь одоо олдоод

байна. Үүнээс Ойрадын Зая бандида Намхайжамц (1599-1662)-ын тод монголоор орчуулсан «Шүтэн барилдсан магтаал» буй мэдээг Академич Ц. Дамдинсүрэн «Зуун билэгт»<sup>7</sup> дурдсан болно. Намхайжамцын уг зохиолыг орчуулсан он тодорхойгүй бөгөөд бодвол монгол орчуулга идэвхийлэн хийж, тод үсгээр бичиж, баралж байсан 1643—1662 оны хооронд орчуулсан болов уу гэж үзэж байна. Үүгээр үзвэл Намхайжамцын орчуулга нь Монгол Данжурын орчуулгаас түрүү үед хийгдсэн байж болох талтай юм. Нөгөө хоёр монгол орчуулгын нэг нь Бээжинд модон бараар хэвлэгдсэн «Номын явдлын зэрэг сайн хувьтны хоолойн чимэг»<sup>8</sup> хэмээх хурлын уншлагын монгол орчуулгын 22-р дэвтэрт оржээ. Энэ зохиолыг Урад гүүш Номун далай (Чойжамц Дарма гүүш) аяга тахимлага эмч Чүлтэмийн дурдсанаар «Шүтэн барилдсан магтаал» гэдэг нэртэйгээр орчуулсан байна. Өрнөд Германы монголч эрдэмтэн В. Хайссиг «Бээжин модон барын монгол номын гарчиг»-таа<sup>10</sup> Урад гүүш Дармаагийн орчуулсан номын нэрсийн жагсаалтын дотор энэ орчуулгын нэрийг дурдсан болно. Энэ орчуулгыг хэдүйд хийснийг уг номын төгсгөлийн үгэнд дурдаагүй байна. Гэвч Дарма гүүш ихэнх орчуулгаа 1707 — 1727 оны хооронд хийж хэвлэсэн байх тул «Шүтэн барилдсан магтаал»-ыг энэ үед орчуулсан гэж үзэж байна. Дарма гүүшийн энэ орчуулга бол төвд эхийн үгийг гол болгон үсэгчлэн буулгасан эртний судрын уламжлалт орчуулга юм.

Төвд эх: /gang zhig gzigs shing gsung ba yi/  
 /mkhyen dang stong pa bla na med/  
 /rgyal ba rten cing 'brel bar 'byung/  
 /gzigs shing doms pa de la dud/

Урад Дарма гүүшийн орчуулга:  
 alimad üjeged nomlagsan iyar  
 ayiladqu ba üjegülgci degere ugei  
 ilayuysan sitügen barildun bolugsan-i  
 üjeged nomlayci tegün-e sögüdümüi

Гуравдахь монгол орчуулгыг Гандантэгчинлин хийдийн шавь, Шашны дээд сургуулийн багш агсан Данзан-Осор (1901— 1978) гавьж «Гүн шүтэн барилдаж бүтсэний үүднээс магтсан сайн номлолын зүрхэн хэмээх оршивой» гэсэн нэртэйгээр 1960-аад оны үед хийсэн байна. Энэ орчуулга нь урьд өмнө судалгааны бүтээлд дурдагдаагүй шинээр мэдэгдэж байгаа бөгөөд бидэнд олдсон хувь бол орчуулагчийн өөрийн гараар уйгаржин монгол үсгээр бичсэн эх болно.<sup>11</sup> Данзан-Осор багшийн орчуулга хэдийгээр сүүлийн үеийн орчуулга боловч Дарма гүүшийн орчуулгын уламжлалын нөлөө аль нэг хэмжээгээр туссан харагдаж байгаа ба Дарма гүүшийн судрын хэлний үгчилсэн орчуулгыг арай ойлгомжтой болгон засварласан тал ч байна.

Төвд эх: /de tse blo dang ldan pa yis/  
 /rten cing 'brel bar byung bali lam/  
 /khyod kyi bstan pa'i gnad nyid du/  
 /ji ltar khong du chud mi 'gyur/

Урад Дарма гүүшийн орчуулга:  
 ter cay tur oyun luv-a tegülder-ber  
 sitüged barildun boluvsan mör  
 cinü sasin-u onisun mönkü  
 yambar ba dotorban oroyulqu ülü bolqu

Гавьж Данзан-Осорын орчуулга:  
 tere cāy tur tegüs oyutan ber  
 sitüged barilduju бүтүгсен мөр-и  
 tan-u nomlal-un cuqum anisun-dur  
 medeji yayun-a ülü bolumui

Энэ бадагт Данзан-Осор blo ldan-г «төгс оюун тан», rten cing "brel bar 'byung-г «Шүтгээд барилдужу бүтэгсэн» khyod kyi-г «Таны « bstan pa'i gnad pyid du-г «номолун чухам анисун дор», гэх мэт төвд эхтэй аль болохоор ойртуулан засахыг эрхэмлэсэн байна. Энэ мэтийн олон жишээнээс Данзан-Осор багшийн утгачилан засварласан орчуулгын гол ялгаа, Дарма гүүшийн орчуулгын уламжлал илрэн харагдана.

Харин монголчууд эдгээр орчуулгуудыг сүм хийдийн хурлын уншлага болгон уншиж байсан ба нөгөө талаараа түүний утга учрыг мэдэх үүднээс эх хэлээрээ уншиж судлах зорилготой байсан байна.

Зонхавагийн энэ магтаалыг санскрит, хинди, англи хэлэнд эрдэмтэн Жалжаннамдол, Агвансамдан нар орчуулан, 1982 онд Энэтхэгийн Сарнат хотод хэвлүүлсэн байна.<sup>12</sup> Энэ бүгдээс үзэхэд «Шүтэн барилдсан магтаал» -ыг төвд хэлнээс анх монголчууд орчуулсан бөгөөд энэ нь Зонхавагийн хоосон чанарын онолтой танилцах боломжийг бий болгож улмаар монголд уг зохиол болон «хоосон чанар»-ын онол хөгжихөд тус дөхөм үзүүлсэн юм. Эдгээр монгол, санскрит, хинди, англи орчуулга нь цаг үеийн хувьд нэлээд зөрөөтэй боловч төвд эхтэйгээ ерөнхийдөө тохирч байгаа ба харин энд дурдсан Жалцаннамдол, Агвансамдан нар «Шүтэн барилдсан магтаал»-ыг анх төвд хэлнээс ямар хэлэнд орчуулсан, монгол орчуулга байдаг үгүй тухай асуудлын огт хөндөөгүй орхисон болно.

## 2. Монголчуудын төвд хэлээр бичсэн тайлбарын тухай

Монголчууд Зонхавагийн «Шүтэн барилдсан магтаал»-ыг зөвхөн эх хэлээрээ орчуулаад зогссонгүй энэхүү зохиолдох «Шүтэн барилдлага» буюу «дундад үзэл»-ийн онолын үндэслэлийг амар хялбар таньж мэдэхэд тус болох үүднээс «утгын хуваарь» буюу савжид, «үгийн тайлбар» буюу цэгдэл, «нэмэлт тайлбар» буюу чандэл зэрэг олон тайлбарыг зохиосон байна. Тэдгээрээс бидэнд мэдэгдээд байгаа тайлбаруудыг дурдвал: Цахар гэвш Лувсанцүлтэм (1710—1740) -ийн «Шүтэн барилдсан магтаалын утгын хуваарь бэрх утгыг анхааран авах ёс сэлт төдийг үзүүлэгч»<sup>13</sup>, Алшаа Дандар лхарамба (1758-1842) гийн «Шүтэн барилдсан магтаалын утгын тайлбар их эрдэний эрих»<sup>14</sup>, Цэмбэл гүүш (XVIII зуун) -ийн «Түн шүтэн барилдсан зарлигийн үүднээс магтсан сайн номлолын зүрхний нэмэлт тайлбар»<sup>15</sup>, Их Хүрээний Бичээч цорж Агвандорж (XIX зуун) -ийн «Шүтэн барилдсан магтаалын хураангуй»<sup>16</sup>, Их Хүрээний цорж Агванбалдан (1797-1864) гийн «Шүтэн барилдсан магтаалын тайлбар үг утгыг өчүүхэн тодруулагч,<sup>17</sup> Жанжа Ролбийдорж (1717—1786)-ийн «Шүтэн барилдсан магтаалын их тайлбар сайн номлолын зэндманий сан хөмрөг»<sup>18</sup> Их Хүрээний Агвантүвдэн ранжинба (XVШ зуун) -ын «Шүтэн барилдсан магтаал сайн номлолын зүрхний утгын хуваарь тодорхой толь»<sup>19</sup>, Их Хүрээний цорж Лувсанчойнзин (XIX зуун)-гийн «Шүтэн барилдсан магтаалын утгын хуваарь, хураангуй утгыг тодруулагч зүрхний толь»<sup>20</sup>, Мэргэн бандида Агван-Ишсамбуу (1847—1896)-гийн «Магтаал сайн номлолын зүрхний тайлбар мэргэдийн сэтгэлийг булаагч»<sup>21</sup> Лувсанлхүндэв бандида (XIX зуун)-гийн «Шүтэн барилдсан магтаал»

лын тайлбар сайн номлолын тодорхой зул<sup>22</sup>. Сайн хааны Зундуйсодов (1866--1929)-ын «Шүтэн барилдсан магтаалын утгын хуваарь»<sup>23</sup>, Зава лам Лувсандамдин (1856-1937)-гийн «Шүтэн барилдсан магтаалын утгын хуваарь»<sup>24</sup> зэрэг болно.

«Шүтэн барилдсан магтаал»-д Төвдийн эрдэмтдийн бичсэн тайлбар маш олон бөгөөд энд тэдний нэрийг дурдсангүй, зөвхөн монгол зохиогчийн төвд хэлээр бичсэн тайлбарыг гаргалаа. Монгол зохиогчдын эдгээр тайлбарт Зонхавагийн «Дэнбэрэлдодва»-гийн хоосон чанарын үзлийн онолын үндэслэлийг амар хялбар болгон тайлбарлаж, түүнийг Энэтхэг, Төвдийн эрдэмтдийн бичсэн бүтээлээр давхар нотлохын зэрэгцээ хоосон чанарын үзэл болон уг зохиолын талаар өөрсдийн баримталдаг үзэл бодлыг дэвшүүлсэн байна.

Эдгээр монгол зохиогч нарын дотроос урьд өмнө нэрд гарч алдаршаагүй боловч маш ховор, гол чухал дорвитой тайлбар бичсэн хүн бол Агван-Ишсамбуу юм.

Агван-Ишсамбуу 14-р жарны улаагчин хонин жил буюу 1847 онд Халх түшээт хан аймгийн засаг Гэпэлдоржийн хошууны (одоогийн Булган аймгийн Бүрэгхангай сумын) нутагт Баянзүрх гэдэг газар Цаян зайсан Батжаргал гэгчийн гэр бүлд төржээ.<sup>25</sup> Тэрбээр багадаа өөрийнхөө нутгийн Шадавдаржаалин хийдэд шавлин сууж тухайн үеийн мэдлэг ухааны салбарт суралцаж мэргэжсэн байна. Нутаг орны хүмүүсийн аман мэдээгээр бол Агван-Ишсамбуу атаархаг хүмүүст хавчигдан нутгаасаа гарч Хяраан харуул, Цонгоол буриадад очиж, тэнд сууж байгаад 1896 онд нас барсан байна. Агван-Ишсамбуу 130 орчим зохиолоос бүрдсэн хоёр боть бүтээл туурвисан байна. Төв үзлийн аймгийн чиглэлээр 19 зохиол бичсэнээ хамгийн дорвитой бүтээл нь бидний өгүүлж байгаа «Дэнбэрэлдодва»-гийн тайлбар болно. Агван-Ишсамбуу энэ тайлбараа 1886 онд зохиосон бөгөөд тэгэхдээ төвд, монголын олон эрдэмтдийн бичсэн тайлбарт тулгуурласан байна. Гэвч Агван-Ишсамбуу тэдгээр эрдэмтдийг мухраар дагасангүй, харин ч уг зохиолын шүлэг бүрийг дэлгэр тайлбарлан, түүнийгээ Энэтхэг, Төвдийн эрдэмтдийн бүтээлээс ишлэл авч батлан, зарим төвдийн эрдэмтдийн бичсэн тайлбарыг шүүмжилж, алдааг засаж, хоосон чанарын онолын талаар өөрийнхөө үзэл бодлыг дэвшүүлсэн бие даасан бүтээлийг туурвисан байна.

«Шүтэн барилдсан магтаал»-ыг монгол хэлнээ орчуулж, тайлбар хийсэн нь буддын гүн ухааны гол үзэл болсон «Дундад үзэл»-ийг болон «Дэнбэрэлдодва»-г судлахад монголчуудын оруулсан чухал хувь нэмэр болно.

<sup>1</sup> Магтаалыг төвдөөр Додва *bstod pa*), санскритаар (*stotragana*) гэж нэрлэдэг бөгөөд Төвд хэлээрх магтаалын төрлийн зохионыг дотор нь «Гүн ухаан», яруу найраг», «намтарчилсан» гэх мэт хэдэн чиглэлд хувааж болно.

<sup>2</sup> «Дэнбэрэлдодва»-гийн хэвлэмэл ( бар) эх зохиогчийн бүрэн зохиолын эмхэтгэлийн 2-р буюу «Kha» ботид 110—114-р талд бий. Уг зохиолыг Төвдийн Гүнбум, монголын Их Хүрээ, бусад олон хүрээ хийдийн барханд янз бүрийн хэмжээтэй хэвлэсэн ба мөн гар бичмэлээр үлэмжхэн тархсан байна.

<sup>3</sup> *rje tham cad mkhyen pa Tzong-kha-pa chen po'i nam thar las le' u inga pa* (Ca) 28 В TAD., УННС-гийн төвд хөмрөгт

<sup>4</sup> *rle tham cad mkhyen pa Tzong-kha-pa chen po' i nam thar: gyi bsdus don* (Ta) 29a-TAL УННС-гийн төвд хөмрөгт

<sup>5</sup> Монгол Данжур, 225-р боть 12а тал. , УННС-гийн монгол номын хөмрөгт

<sup>6</sup> Тогтохтөрийн «Цагаан толгойн үсгийн туурвисан оюун билгийн соёрхол» (оршил) УННС-гийн монгол номын хөмрөгт

<sup>7</sup> Ts. Damdinsuren, *Mongol uran jokiyal-un javun bilig orusiba*. CSM., Tom. XIV., UB. 1957;

<sup>8</sup> "chos spyod kyi rim pa skal bzang mgrin rgyan" Цаасны хэмжээ 39 x 8,5 см. ,

Барын хэмжээ 31 x 5,6 см. , нийт 60 гаруй номын монгол орчуулга бий. Бээ жин бар, УНШС-гийн монгол намын хөмрөгт

<sup>9</sup> Дарма гүүш. , "sitün barilduvsan maytayal kemegdekü orusiba" Цаасны хэмжээ

39 x8,5 см, Барын хэмжээ 31,4 x 5,6см Хуудасны тоо 7...Бээжин бар, УННС-гийн монгол номын хөмрөгт

<sup>10</sup> W.Heissig Dei Pekinger Lamaistischen Blockdrucke in mongolischer sprache. WIESBADEN. 1954. NO. 66, p.55-58

<sup>11</sup> Данзан-Осор, "gün sitüged barilduju бүтүгсен-и номlaysan-у egüden-еце maytaysan sayin nomlal-un jerqün kemekü orosibai: : Цаасны хэмжээ 24 x 8,2 см. , Хуудасны тоо 7, Гар бичмэл, Хувийн номын санд

<sup>12</sup> PRATITYASAMUTPADASTUTISUBHASITAHRDAYAM OF ACARYA TSONK HAPA Translated by Gyalten Namdol, Ngawang Samten, Sarnath. 1982

<sup>13</sup> rten 'brel bstod pa' sa bcad ldem dgongs kyi gsung 'ga'i don nyams su len tsul bcas mdo hzam bstan pa, x.12., "Kha" буюу 2-р ботийн дотор. , УННС-гийн төвд хөмрөгт

<sup>14</sup> rten brel bstod pa' i dga gnas las brtzams pa'i don 'grel rin chen phren ba, x. 26. , "Ka" буюу 1-р ботийн дотор., УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>15</sup> zab mo rten 'byung gsung pa' i 'bstod pa legs bshad snying po'i mchan 'grel, x. II., "Kha" буюу 2-р ботийн дотор., УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>16</sup> rten brel bstod pa' i bsdus pa, x. 6. , "Nga" буюу 4-р ботийн дотор. , УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>17</sup> rten 'brel bstod pa i'grel ba tsig:nyung don gsal, x. 15 Дандар арга

<sup>17</sup> rten brel bstod pa' i grel ba tsig nyung don gsal, x. 15 Дандар аграмбын «Ka» буюу 1-р ботийн дотор. , УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>17</sup> rten 'brel bstod pa'i tikka legs bshad nor bu' i bang mdzod, x. 57., буюу 2-р ботийн дотор., УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>19</sup> rten 'brel bstod pa legs bshad snying pa' i sa bcad gsai ba i me long x. 10., "Kha" буюу 2-р ботийн дотор. , УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>20</sup> rten 'brel bstod pa' i sa bcad bsdus don rab gsal sning gi me long, x. I., "Ka" буюу 1-р ботийн дотор. , УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>21</sup> bstod pa legs shad snying po' i 'grel pa mkhas pa' i yid "phrog, x. 212, "Kha" буюу 2-р ботийн дотор. , Зохиогчийн хувийн номын санд

<sup>22</sup> rten brel bstod pa' i grel pa legs shad gsal agron, x, 36 Гар бичмэл, Зохиогчийн хувийн номын санд

<sup>23</sup> rten brel bstod pa'i sa bcad, x. 4. , "Ka" буюу 1-р ботийн дотор. , УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>24</sup> rten "brel bstod pa' i sa bcad, x.I., "Nga" буюу 4-р ботийн дотор, УННС-гийн төвд номын хөмрөгт

<sup>25</sup> bstan pa' i gsal. byed Er-te-ni Mer-gen pandi-ta bla ma'i gsang ba'i nam thar, x. 17. , "Ka" буюу 1-р ботийн дотор "Nga—42 Зохиогчийн хувийн номын санд

**ЗАРИМ ХЯТАД РОМАНЫ  
МОНГОЛ ОРЧУУЛГЫН  
ТУХАЙД**

**Ж. Баттөр**

Монгол, хятад хоёр улс, орчлон тэргүүлэшгүй цагаас аваад нутаг савлан оршоор ирсэн үлэмж их түүхт, эртний соёл улсууд билээ. Иймд тус хоёр улсын ард түмний хооронд эдийн болоод оюуны соёлын лут их ялгаа буйн зэрэгцээ Энэтхэг, Төвд, Хятад, Манж, Монголын түүх соёлын хүрээ, ерөөс нийт Азийн соёлын хүрээ гэсэн ойлголтын үүднээс үзвэл олон салбарт нэлээд ойр дөт харилцаатай байж, тэрхүү харилцаа ч үлэмжхэн зүйлд ул мөрөө үлдээжээ..